



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын байцаагчийн 2017 оны 07-07-027/164 дүгээр дүгнэлтээр тогтоогдсон нийт 313,107,000.00 (гурван зуун арван гурван сая нэг зуун долоон мянган) төгрөгийн балансын үнэ, 272,373,140.00 (хоёр зуун далан хоёр сая гурван зуун далан гурван мянга нэг зуун дөчин) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга А.Даваадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Албан конторын зориулалттай газрыг зориулалтын бусаар, арилжааны зорилгоор ашиглахгүй байх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Ц.ЦАГААНХҮҮ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 05 -ны өдрийн
48 дугаар тогтоолын хавсралт

Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт



Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл үнэ /төгрөг/
1	Барилга /контор/	м.кв	430	1954	313,107,000.00	272,373,140.00	40,733,860.00
	Нийт дүн				313,107,000.00 (гурван зуун арван гурван сая нэг зуун долоон мянган)	272,373,140.00 (хоёр зуун далан хоёр сая гурван зуун далан гурван мянга нэг зуун дөчин)	40,733,860.00 (дөчин сая долоон зуун гучин гурван мянга найман зуун жаран)